



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар АА56

Булган сум

“Мал мах-2024” хэсэгчилсэн арга хэмжээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.21, 60 дугаар зүйлийн 60.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 28.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал хулгайлах, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус ан, зөвшөөрөлгүй мод, модон бүтээгдэхүүн бэлтгэх, тээвэрлэх гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, шалган шийдвэрлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа “Мал, мах-2024” хэсэгчилсэн арга хэмжээнд 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д даалгасугай.

3. Тус арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, ажлын тайланг аймгийн Засаг даргад 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр), Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр), Мал эмнэлгийн газрын дарга (Г.Одсүрэн) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011105